

БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2020 оны III улирлын тайлан*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын  
IV байр. Утас: 51-261668

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт .....	3
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	4
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт.....	6
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	6
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт .....	7
Статистик үзүүлэлтүүд .....	7
Харилцагчид, зээлдэгчид.....	8
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид .....	8
Тархалт .....	9
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	10
Мөнгөн хөрөнгө.....	11
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	11
Факторингийн тооцооны авлага.....	11
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө .....	11
Зээл.....	12
Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	13
Бусад хөрөнгө .....	14
Эргэлтийн бус хөрөнгө .....	14
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	15
Санхүүгийн эх үүсвэр .....	16
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг .....	16
Бусад эх үүсвэр .....	17
ББСБ-аас гаргасан өрийн бичиг .....	17
Төслийн зээлийн санхүүжилт .....	18
Бусад өр төлбөр .....	18
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	18
Бусад өмч, сангууд .....	19
Хуримтлагдсан ашиг .....	19
Хоёрдогч өглөг.....	20
Ашигт ажиллагаа .....	21
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	23
Дүгнэлт .....	24

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл .....	4
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ .....	4
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа .....	4
Хүснэгт 6 Харилцагчдын мэдээлэл.....	7
Хүснэгт 7 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	8
Хүснэгт 8 ББСБ-ын мэдээлэл .....	8
Хүснэгт 9 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	8
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт .....	9
Хүснэгт 11 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт .....	9
Хүснэгт 12 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	10
Хүснэгт 13 Активын интервал /тэрбум төгрөгөөр/ .....	10

Хүснэгт 14 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	11
Хүснэгт 15 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 16 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	11
Хүснэгт 17 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 18 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 19 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	13
Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	14
Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/.....	16
Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	16
Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 30 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 32 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 33 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 34 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 35 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 36 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/.....	19
Хүснэгт 37 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	20
Хүснэгт 39 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/.....	21
Хүснэгт 40 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 41 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	23

### Зургийн жагсаалт

Зураг 1 ББСБ-уудын тархалт.....	9
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	10
Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/.....	12
Зураг 4 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	15
Зураг 5 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 6 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/.....	17
Зураг 7 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	17
Зураг 8 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	19
Зураг 9 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	21

### Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2020 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 533 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 ББСБ буюу 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 77 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2016.III	2017.III	2018.III	2019.III	2020.III
Шинээр олгосон	63	9	13	9	12
Хүчингүй	4	7	7	9	8
Түдгэлзүүлсэн	0	1	17	10	25
Сэргээсэн	1	8	7	8	4
<b>Нийт ББСБ</b>	<b>509</b>	<b>535</b>	<b>540</b>	<b>539</b>	<b>533</b>
Үүнээс: ХОН	59	70	76	74	77
Үүнээс: ГХО	30	29	28	28	29
Салбар	117	139	206	240	285
Төлөөлөгч	4	4	5	7	9

2020 оны III улирлын байдлаар 12 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 8 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгож, 25 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлж, 4 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2020 оны III улирлын байдлаар 15 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2019.III	2020.III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,628.5	1,942.1	19.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.7%	5.6%	0.9%
Нийт өөрийн хөрөнгө	1,202.5	1,376.6	14.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	38.8%	46.1%	7.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	909.2	979.5	7.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	107.2%	130.5%	23.3%
Нийт зээл	1,169.3	1,357.8	16.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.5%	7.6%	1.1%
Нийт орлого	250.6	303.9	21.3%
Нийт зарлага	150.4	189.3	25.9%
Цэвэр ашиг	100.2	114.6	14.4%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар өсөж, банкны салбарын 5.6%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

2020 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар буюу 313.5 тэрбум төгрөгөөр өсөж 1.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 60.1 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 55.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 21.3 хувиар буюу 53.3 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 25.8 хувиар буюу 38.9 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 14.4 хувиар буюу 14.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2019.III	2020.III	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		539	533	-6	-1.1%
1	Зээл	494	495	1	0.2%
Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		348	333	-15	-4.3%
2	Факторинг	28	34	6	21.4%
3	Төлбөрийн баталгаа гаргах	19	20	1	5.3%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	5	2	66.7%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	29	33	4	13.8%
6	Гадаад валютын арилжаа	155	153	-2	-1.3%
Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		45	38	-7	-15.6%
7	Итгэлцэл	31	42	11	35.5%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	10	-	-
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	32	37	5	15.6%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 533 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.9% нь буюу 495 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 62.5% нь буюу 333 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 153 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.7 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.1% бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар, итгэлцэлийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өссөн байна. 2020 оны III улирлын тайлан мэдээний ирц 98.1% байна.

Тайлан мэдээг ирүүлбэл зохих 533 ББСБ-аас 523 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 10 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

## Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ыг боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [370 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4586 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [441 дүгээр ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4622 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [10 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн [122/58 тоот хамтарсан тушаалаар](#) өөрчлөлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс

2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэр гаргасан.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-д 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн [148 дугаар тогтоол](#)оор өөрчлөлт оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан.

- “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [352 дүгээр тогтоол](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авсан.

- “Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [495 дугаар тогтоол](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4835 дугаараар бүртгүүлсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдөр “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай [854 дүгээр тогтоолыг](#) баталж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд мөрдөж ажиллах шийдвэр гаргаад байна.

**“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт**

2020 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн

аудитаар баталгаажуулах үүргийг 96.1% буюу 517 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 450 ББСБ хэрэгжүүлсэн байна.

### “Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 495 ББСБ-ын 80.6% буюу 399 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

### “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон

гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 166 ББСБ, 9,305 удаагийн тохиолдлоор, 935.6 тэрбум төгрөгийг, 7.2-г “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 48 удаагийн тохиолдлоор, 40.1 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2020 оны III улирлын байдлаар нийт 520 ББСБ-аас 1.2 тэрбум төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 75.0% буюу 397 ББСБ 880.7 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

### Статистик үзүүлэлтүүд

2020 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 8,669 хувь нийлүүлэгчдийн 533 ББСБ, 285 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,417 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,639,297 харилцагч, 551,977 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	2,639,297	258,255	2,381,042	36,001	2,624,200	15,097	504,752	2,134,545	30,646
Үүнээс: Эмэгтэй	1,354,459	132,869	1,221,590	20,225	1,346,442	8,017	289,784	1,064,675	16,603
Эрэгтэй	1,279,934	120,771	1,159,163	14,684	1,272,890	7,044	214,631	1,065,303	13,826
Хуулийн этгээд	4,904	4,615	289	1,092	4,868	36	337	4,567	217
Итгэмжлэгчдийн тоо	2,780	2,456	324	-	2,779	1	306	2,474	298
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	937	247	690	-	925	12	688	249	63
Зээлдэгчдийн тоо	551,977	163,409	388,568	-	537,309	14,668	205,884	346,093	30,565
Хэвийн	482,487	147,672	334,815	-	469,787	12,700	173,897	308,590	27,148
Хугацаа хэтэрсэн	25,925	6,201	19,724	-	25,260	665	9,009	16,916	658
Чанаргүй:	43,565	9,536	34,029	-	42,262	1,303	22,978	20,587	2,759
-Хэвийн бус	8,869	3,198	5,671	-	8,659	210	3,194	5,675	895
-Эргэлзээтэй	16,700	2,379	14,321	-	16,265	435	10,033	6,667	654
- Муу	17,996	3,959	14,037	-	17,338	658	9,751	8,245	1,210
Зээлдэгчдийн насжилт	550,514	162,017	388,497	-	535,882	14,632	205,765	344,749	30,362
18-35 насны	332,311	67,197	265,114	-	326,945	5,366	125,198	207,113	12,636

36-45 насны	198,021	118,459	79,562	-	192,997	5,024	50,538	147,483	9,436
46-55 насны	65,421	30,650	34,771	-	62,350	3,071	23,259	42,162	6,306
55-аас дээш	19,030	9,980	9,050	-	17,859	1,171	6,770	12,260	1,984
Зээлдэгчдийн боловсрол	550,514	162,017	388,497	-	535,882	14,632	205,765	344,749	30,362
-Дээд	361,531	90,469	271,062	-	354,413	7,118	115,037	246,494	13,467
-Тусгай дунд	38,825	20,976	17,849	-	35,938	2,887	6,094	32,731	4,664
-Бүрэн дунд	122,494	42,828	79,666	-	119,491	3,003	72,060	50,434	11,231
-Дунд	22,138	5,863	16,275	-	20,979	1,159	9,395	12,743	951
-Бага	5,526	1,881	3,645	-	5,061	465	3,179	2,347	49

### Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 67.5 хувиар өсөж 2,639,297-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43.9 хувиар өсөж 551,977-д хүрлээ.

Нийт харилцагчдын 90.2% буюу 2,381,042 нь, зээлдэгчдийн 65.8% буюу 293,307 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 9.8% буюу 258,255, зээлдэгчдийн 29.6% буюу 163,409 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 36,001 буюу нийт харилцагчдын 1.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2016.III	2017.III	2018.III	2019.III	2020.III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	937	1,039	4,766	7,672	8,669	997	13.0%
Ажилчдын тоо	1,875	2,289	2,652	3,003	3,417	414	13.8%
Харилцагчдын тоо	432,704	1,392,561	1,510,982	1,575,389	2,639,297	1,063,908	67.5%
Зээлдэгчдийн тоо	64,278	102,957	217,623	383,670	551,977	168,307	43.9%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	4.2%	3.4%	3.3%	3.1%	3.0%	-0.1 пункт	

### Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 7,640 буюу 88.1% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,029 буюу 11.9% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,107 буюу 12.8% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 181 буюу 2.1% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,669	2,047	6,622	62	8,488	181	7,640	1,029	1,107
Нийт ажилтнуудын тоо	3,417	2,930	487	118	3,211	206	232	3,185	371
Үүнээс: Эмгэгтэй ажилтны тоо	1,999	1,745	254	70	1,858	141	135	1,864	201

Хөдөө орон нутгийн 77 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
<b>ТЗ-тэй ББСБ-ын тоо</b>	<b>533</b>	<b>518</b>	<b>15</b>	<b>38</b>	<b>457</b>	<b>76</b>	<b>4</b>	<b>529</b>	<b>29</b>	<b>504</b>
1 Зээл	495	480	15	-	420	75	4	491	29	466
2 Факторингийн үйлчилгээ	34	26	8	-	34	-	2	32	2	32
3 Төлбөрийн баталгаа гаргах	20	18	2	-	20	-	1	19	5	15
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	1	4	-	5	-	1	4	-	5
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	33	26	7	-	33	-	2	31	1	32
6 Гадаад валютын арилжаа	153	145	8	38	146	7	3	150	9	144
7 Итгэлцлийн үйлчилгээ	42	36	6	-	41	1	3	39	4	38
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	8	2	-	9	1	2	8	2	8
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	37	32	5	-	36	1	4	33	5	32
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-	-	-

## Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.6% буюу 456 ББСБ, салбаруудын 66.7% буюу 190 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.4% буюу 77 ББСБ, салбаруудын 33.3% буюу 95 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 1 ББСБ-уудын тархалт



2020 оны III улирлын байдлаар 79 ББСБ-ын 285 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 58.0 хувийг 11 ББСБ-ын 166 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	77	94		171
Архангай аймаг	1	2	3	1.7%
Баян-Өлгий аймаг	3	1	4	2.3%
Баянхонгор аймаг	4	5	9	5.2%
Булган аймаг	2	-	2	1.2%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.3%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.5%
Дорноговь аймаг	2	6	8	4.7%
Дорнод аймаг	5	7	12	7.0%
Дундговь аймаг	1	3	4	2.3%
Завхан аймаг	2	2	4	2.3%
Орхон аймаг	7	13	20	11.6%
Өвөрхангай аймаг	7	6	13	7.6%
Өмнөговь аймаг	1	10	11	6.4%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.7%
Сэлэнгэ аймаг	5	6	11	6.4%

Төв аймаг	13	3	16	9.3%
Увс аймаг	2	4	6	3.5%
Ховд аймаг	1	3	4	2.3%
Хөвсгөл аймаг	3	4	7	4.1%
Хэнтий аймаг	3	4	7	4.1%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	456	190		646
Сүхбаатар дүүрэг	162	30	192	29.7%
Чингэлтэй дүүрэг	133	26	159	24.6%
Баянгол дүүрэг	72	33	105	16.3%
Баянзүрх дүүрэг	51	47	98	15.2%
Хан-Уул дүүрэг	30	20	50	7.7%
Сонгинохайрхан дүүрэг	7	28	35	5.4%
Багануур дүүрэг	1	4	5	0.8%
Налайх дүүрэг	-	2	2	0.3%

## Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2020 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.3 хувиар буюу 313.5 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 60.1 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2019.III	Нийт дүнд эзлэх хувь	2020.III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,571,920.0	96.5%	1,868,764.5	96.2%	296,844.5	18.9%
Мөнгөн хөрөнгө	342,913.2	21.1%	415,202.6	21.4%	72,289.4	21.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	2,373.4	0.1%	9,628.1	0.5%	7,254.7	305.7%
Зээл (цэврээр)	1,090,929.1	67.0%	1,263,734.5	65.1%	172,805.4	15.8%
<b>Нийт зээл</b>	<b>1,169,270.1</b>	<b>71.8%</b>	<b>1,357,823.9</b>	<b>69.9%</b>	<b>188,553.8</b>	<b>16.1%</b>
(Зээлийн эрсдэлийн сан)	78,341.0	4.8%	94,089.4	4.8%	15,748.4	20.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	4,187.5	0.3%	4,788.1	0.2%	600.6	14.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	9,277.4	0.6%	10,854.8	0.6%	1,577.4	17.0%
Бусад хөрөнгө	122,239.3	7.5%	155,994.1	8.0%	33,754.8	27.6%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэлийн авлага	-	-	8,562.2	0.4%	8,562.2	-
Эргэлтийн бус хөрөнгө	56,600.9	3.5%	73,296.8	3.8%	16,695.9	29.5%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	69,577.4	4.3%	91,459.0	4.7%	21,881.6	31.4%
(Хуримтлагдсан элэгдэл)	-12,976.5	-0.8%	-18,162.2	-0.9%	-5,185.7	40.0%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,628,520.9</b>	<b>100.0%</b>	<b>1,942,061.2</b>	<b>100.0%</b>	<b>313,540.3</b>	<b>19.3%</b>

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2016 оны мөн үед 724.2 тэрбум төгрөг байсан бол 2020 оны III улирлын байдлаар 2.7 дахин өсөж 1.9 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 3.1 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 74.3% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 169 ББСБ, 31.7% нь 2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 364 ББСБ-ын хөрөнгө байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,091.2	62	56.2%	11.6%	5.7	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	351.6	107	18.1%	20.1%	5.9	2	4.1	1	-	-
1.9-2.5 тэрбум	213.7	100	11.0%	18.8%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	211.7	131	10.9%	24.6%	154.1	1	3.2	2	1.7	1
0.6-1.4 тэрбум	51.6	46	2.7%	8.6%	5.2	6	8.4	9	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	22.3	87	1.2%	16.3%	1.0	3	12.2	52	8.8	33
<b>НИЙТ</b>	<b>1,942.1</b>	<b>533</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>171.9</b>	<b>13</b>	<b>27.9</b>	<b>64</b>	<b>14.4</b>	<b>38</b>

## Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн 40.4% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 29.3% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 30.3% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	415.2	365.4	49.8	13.7	403.7	11.5	31.0	384.2	59.8
Бэлэн мөнгө	167.8	165.2	2.6	12.5	160.3	7.5	0.0	167.8	4.9
Харилцах	121.5	102.4	19.0	1.1	117.6	3.8	10.2	111.2	19.7
Хадгаламж	126.0	97.8	28.2	0.1	125.8	0.2	20.8	105.2	35.1

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 45.2%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 5.1%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 91.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

## Богино хугацаат хөрөнгө оруулалт

2020 оны III улирлын байдлаар 17 ББСБ 9.6 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 41.0% буюу 3.9 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 59.0% буюу 5.7 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 88.9% буюу 8.5 тэрбум төгрөг нь хувьцаа, 11.6% буюу 1.1 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 0.1% буюу 5.0 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	9,628.1	8,350.0	1,278.1	1.0	8,971.7	656.4	7,395.5	2,232.6	6,117.4
Хувьцаа	8,501.5	7,223.4	1,278.1	1.0	7,845.1	656.4	6,824.7	1,676.8	5,546.6
Бусад	1,121.6	1,121.6	-	-	1,121.6	-	570.8	550.8	570.8
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	5.0	5.0	-	-	5.0	-	-	5.0	-
Арилжааны үнэт цаас	5,679.5	5,590.5	89.0	-	5,678.5	1.0	5,635.6	43.9	5,546.6

## Факторингийн тооцооны авлага

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2019.III		2020.III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
Хэвийн	4,223.6	100.0%	4,836.7	100.0%	557.9	13.8%
Хугацаа хэтэрсэн	105.0	2.5%	188.1	3.9%	83.1	79.1%
Чанаргүй	66.0	1.6%	38.2	0.8%	(27.9)	-42.2%
Хэвийн бус	16.6	0.4%	13.3	0.3%	(3.3)	-19.8%
Эргэлзээтэй	45.4	1.1%	12.6	0.3%	(32.9)	-72.3%
Муу	4.0	0.1%	12.3	0.3%	8.3	206.7%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	36.1	0.9%	48.6	1.0%	12.5	34.5%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо нэмэгдсэн хэдий ч 2020 оны III улирлын байдлаар Улаанбаатар хотод байршилтай, уламжлалт санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 6 ББСБ 226.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 48.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 4.8 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 34 ББСБ-уудын 28 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

## Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөг буюу 17.0 хувиар өсөж 10.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
<b>ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)</b>	10,854.8	9,869.3	985.5	10,734.9	119.9	21.3	10,833.5	2,068.9	8,785.9
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	12,241.7	10,686.1	1,555.6	12,124.7	116.9	767.9	11,473.8	2,407.2	9,834.5
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	4,263.4	3,681.1	582.2	4,263.4	-	746.6	3,516.7	1,161.5	3,101.9
Өмчлөх бусад хөрөнгө	2,876.5	2,864.4	12.1	2,873.5	3.0	-	2,876.5	823.2	2,053.3

### ЗЭЭЛ

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.1% буюу 188.5 тэрбум төгрөгөөр өсөж 2020 оны III улирлын байдлаар 1,357.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 94.0 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,263.7 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	1,263.7	1,073.7	190.0	1,235.0	28.7	131.5	1,132.2	204.3	1,059.4
Нийт зээл	1,357.8	1,160.3	197.5	1,323.8	34.0	137.3	1,220.5	216.8	1,141.0
ЭЖДХ /нийт/	2.9%	2.9%	3.3%	3.0%	3.3%	3.4%	2.9%	2.8%	2.9%
Хэвийн	1,177.8	997.0	180.8	1,150.6	27.2	125.5	1,052.3	193.0	984.8
Хугацаа хэтэрсэн	52.1	45.3	6.8	51.2	0.9	3.2	49.0	6.6	45.6
Чанаргүй:	127.9	118.0	9.9	122.1	5.8	8.7	119.2	17.3	110.7
-Хэвийн бус	31.4	29.2	2.3	31.1	0.3	2.8	28.6	5.3	26.2
-Эргэлзээтэй	29.7	25.9	3.8	29.0	0.7	2.9	26.9	3.2	26.6
-Муу	66.7	62.9	3.8	62.0	4.8	3.0	63.7	8.8	57.9
(Зээлийн эрсдэлийн сан)	94.1	86.6	7.5	88.8	5.3	5.8	88.3	12.5	81.6
Нийт зээл (төгрөгийн)	1,322.4	1,128.8	193.6	1,288.5	33.9	125.5	1,197.0	200.3	1,122.1
Нийт зээл (валютын)	35.4	31.5	3.9	35.4	0.1	11.8	23.6	16.5	19.0
Зээлдэгчдийн тоо	551,977	163,409	388,568	537,309	14,668	205,884	346,093	30,565	521,412

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Оны эхэнд 1.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 1.2 их наяд төгрөгийн зээлийг 2.9 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 1.1 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2020 оны III улирлын байдлаар 1.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 86.7 хувийг буюу 1,177.8 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 3.8 хувийг буюу 52.1 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 9.4 хувийг буюу 127.9 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр өссөн бол хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ харгалзан 0.1, 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 180.1 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 52.3%-д буюу 94.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт олгосон зээлийн 64.4% буюу 772.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 11.9% буюу 142.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 65.6% буюу 712.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 13.8% буюу 149.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

*Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/*

Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Хэрэглээ	772.6	64.4%	712.6	65.6%	687.4	50.6%
Бөөний болон жижиглэн худалдаа	142.9	11.9%	149.5	13.8%	202.7	14.9%
Барилга	88.4	7.4%	68.3	6.3%	155.0	11.4%
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	38.3	3.2%	23.6	2.2%	74.2	5.5%
Уул уурхай, олборлолт	23.1	1.9%	27.1	2.5%	45.2	3.3%
Машин мотоциклийн засвар үйлчилгээ	29.0	2.4%	18.8	1.7%	36.3	2.7%
Боловсруулах үйлдвэрлэл	17.6	1.5%	15.2	1.4%	28.7	2.1%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	13.5	1.1%	16.1	1.5%	25.2	1.9%
Бусад	75.0	6.2%	55.7	5.1%	103.1	7.6%
<i>Иргэн</i>	<i>1,082.1</i>	<i>90.1%</i>	<i>989.2</i>	<i>91.0%</i>	<i>1,161.5</i>	<i>85.5%</i>
<i>Хуулийн этгээд</i>	<i>118.3</i>	<i>9.9%</i>	<i>97.7</i>	<i>9.0%</i>	<i>196.3</i>	<i>14.5%</i>
<b>Нийт дүн</b>	<b>1,200.4</b>	<b>100.0%</b>	<b>1,086.9</b>	<b>100.0%</b>	<b>1,357.8</b>	<b>100.0%</b>

Олгосон зээлийн 90.1% буюу 1,082.1 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд, 9.9% буюу 118.3 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.0% буюу 989.2 тэрбум төгрөг нь иргэдээс, 9.0% нь буюу 97.7 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

### Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2020 оны III улирлын байдлаар 15 ББСБ үзүүлж байна.

2020 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшнээр 344,995 зээлдэгчид 83.0 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Нэг зээлдэгчид дундажаар 240.7 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлдэгчийн дундажаас 29.5 дахин бага байна.

*Хүснэгт 18 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд*

№	Финтек	App нэр
1	Мобифинанс	Monpay
2	Нөмөр кредит	Numur
3	Централ капитал	Kmobi
4	Монголиа импакт финанс	Qmoni
5	Инвескор хэтэвч	Pocket.mn
6	Ардкредит	Ard app
7	Жи Эс Би Капитал	GSB capital
8	Зээл Эм Эн платформ	Zeel.mn
9	Лэндмн	Lendmn
10	Ти финанс	T-finance
11	Соно финтек	Sono mongolia
12	Говь финанс	Cash One
13	Ашид капитал	Simple
14	Хатан суудал инвест	Zeely
15	Смарткапитал фанд	Mycredit.mn

## Бусад хөрөнгө

